



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/11

Арвайхээр

Буцаан олголт авах татвар төлөгчдийн
жагсаалт батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тушаалаар батлагдсан "Илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгах журам"-ын 2.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан татвар төлөгчийн буцаан олголт авах хүсэлт, тэдгээрийн 2020 оны жилийн эцсийн албан татварын хүлээн тайланг үндэслэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан "Хөнгөлөлтийн дагуу буцаан олголт авах татварын төлөгчийн жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтад дурьдсан нэр бүхий татвар төлөгчид олговол зохих 5,471,326.21 (Таван сая дөрвөн зуун далан нэгэн мянга гурван зуун хорин зургаан төгрөг хорин нэгэн мөнгө)-ний буцаан олголтын жагсаалтыг Татварын ерөнхий газрын Орлогын хяналт, буцаан олголтын хэлтэст хүргүүлэхийг Жижиг татвар төлөгчтэй харилцах тасагт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Дашхорол)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭСУВД



116128578

Хавсралт

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ХӨНГӨЛӨЛТ БУЦААН ОЛГОХ ЖАГСААЛТ**

(төгрөг)

д/д	Татвар төлөгчийн дугаар	Татвар төлөгчийн нэр	Банкны нэр	Дансны дугаар	Буцаан олгох дүн
1	3563642	Нэмэх төгрөг ББСБ	ХААН	5564045794	5,471,326.21
Нийт					5,471,326.21

БОЛОВСРУУЛСАН:

ЖИЖИГ ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ ХАРИЛЦАХ ТАСГИЙН
ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧ Р.НАРАНЧУЛУУН

ХЯНАСАН:

ЖИЖИГ ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ ХАРИЛЦАХ
ТАСГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ДАШХОРОЛ

